

БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ..... 2

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Монгол хэлний хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх
арга зүйн зөвлөмж..... 5

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар15

Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал.....22

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.




⁴Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Монгол хэлний хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

БАГА БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР-ыг боловсруулан, шалгуурыг хэрхэн хэрэглэх зөвлөмжийг багш та бүхэнд хүргэж байна. Сургалтын үр дүнг үнэлэх шалгуур бүхий бүтээгдэхүүн нь дараах бүтэцтэй юм.

1. Үнэлгээний нэгж
2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүн
3. Үнэлгээний шалгуур, тэдгээрийн гүйцэтгэлийн түвшин



Жишээ болгон нэг ангийн үнэлгээний нэгж болон суралцахуйн үр дүн, шалгуур, гүйцэтгэлийн түвшнийг хүснэгтээр харуулья.

V ангийн МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН суралцахуйн үр дүн, түүний шалгуур

Сурагчдын эзэмших чадвар	Үнэлгээний нэгж	Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Унших чадвар	Уншсанаа ойлгох 5.1а, 5.1б, 5.1в, 5.1г, 5.1д, 5.1е, 5.1ж, 5.1з	Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншдаг болно.	Сурагч 97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэдэг.
		Эхийн гол санааг гарчиг болон зохиолчийн хэлэх гэсэн санаатай холбон тайлбарладаг.	
		Эхлэл, гол, төгсгөл хэсэг дэх үйл явдал, баатруудын хийсэн үйлдлийн хоорондын холбоо хамаарлыг оновчтой жишээ татан тайлбарладаг.	
		Уншсан эх дэх хэтрүүлсэн (эсвэл хүншүүлсэн) дүрслэлийг тайлбарлахдаа оновчтой жишээ татан тайлбарладаг.	
		Уншсан эхэд бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгадаг.	
		Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг бичигчийн зорилго, хэмжээ, үгийн сонголтоор нь харьцуулдаг.	
	Уншсанаа бүтээлчээр ойлгох 5.1к, 5.1л	Зохиолыг унших явцдаа төсөөлж, таамаглах чадвараа харуулна.	Үйл явдлыг өрнүүлэхдээ газар орон, цаг хугацааг оновчтой үгээр илэрхийлэн, ургуулан бодож, өөрийн оюун дүгнэлтээр төсөөлдөг. Онъсогын далд утга буюу адилтгагдаж байгаа юмс үзэгдэл, адилтгаж байгаа юмсын ижил төстэй шинжийг харьцуулсны үндсэн дээр таамагладаг.

Бичих чадвар	Зөв бичих 5.2а, 5.2б	Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна	Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийн дагуу зөв бичдэг. Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, дүрмийн дагуу зөв бичдэг.
	Зохион найруулж бичих 5.2в, 5.2г 5.2д, 5.2е 5.2ж, 5.2з 5.2и, 5.2к, 5.2л 5.2м 5.4а, 5.4б 5.4в, 5.4г	Сурагч өгөгдсөн бүтцийн дагуу эх зохиож, товчилж, ятгаж, илэрхийлж найруулж бичиж чаддаг болсон байна. /богино өгүүллэг, захидал, өдрийн тэмдэглэл, мэдээ, харилцан яриа, оньсого, үлгэр/	Зохиолын агуулгыг товчлохдоо гол санааг хураангуйлан, цөөн үгээр ойлгомжтой, зөв бичгийн дүрмийн алдаагүй хичээнгүй, хурдтай бичдэг.
			Баримт (зураг, график гэх мэт) хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлэхдээ ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн алдаагүй хичээнгүй, хурдтай бичдэг.
			Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн үг хэрэглэн, эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, хурдтай зөв бичгийн дүрмийн алдаагүй захидал бичиж чаддаг.
			Бусдын анхаарлыг татсан үг, баримт, зураг хэрэглэн ятгаж, ойлгомжтой, хичээнгүй бичдэг
			Чухал, шинэ үйл явдлыг бичихдээ эхлэл хэсэгт хэн, хэзээ, хаана, юу болсныг товч, гол хэсэгтээ баримтаар дэлгэрүүлэн, учир шалтгаан, нөхцөл байдлыг тодруулан, төгсгөл хэсэгтээ мэдээ бичсэн хүний нэрийг тус тус алдаагүй, зөв, ойлгомжтой, хичээнгүй, хурдтай бичиж илэрхийлдэг.
			Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, нөхцөл байдал, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа алдаагүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, хичээнгүй, хурдтай бичиж илэрхийлдэг.
			Өөрт тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр дэлгэрүүлэн өдрийн тэмдэглэл зохиохдоо эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй, хурдтай бичдэг.
			Таалгах гэж байгаа эд юмсынхаа шинжтэй адил төстэй зүйлийг харьцуулан, орлуулан оньсого зохиохдоо ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй бичдэг.
			Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн зохиохдоо зохиолын санааны дагуу яриаг өрнүүлэн сонирхолтой, үнэмшилтэй, ойлгомжтой, алдаагүй, хашилт, хаалтыг зөв хэрэглэн, хичээнгүй, хурдтай бичдэг.
Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүллэг зохиохдоо орон байр, улирал, цаг агаар, цаг хугацааг тусган ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв, хичээнгүй, цогцолборуудыг догол мөрөөр зааглан бичиж илэрхийлдэг.			

Сонсох- ярих чадвар	Бусдыг ойлгон сонсох, санаа бодлоо илэрхийлэн харилцах 5.3а, 5.3б 5.3в	Сурагч хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо илэрхийлж, бусдын санаа бодлыг харьцуулж дүгнэж чаддаг болсон байна.	Бусдын санаа бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулж дүгнэж сонсдог.
			Хэлэлцэх, илтгэх үед үзэл бодлоо илэрхийлэхдээ зураг, бүдүүвч схем, хүснэгтэн мэдээлэл зэргийг хэрэглэн, ойлгомжтой, товч тодорхой, оновчтой ярьдаг.
		Хэлэлцэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан байна.	Сонссон зүйлийнхээ гол санааг тулгуур бичиглэл, товч өгүүлбэрээр илэрхийлж, зөв сонссон гэдгээ харуулж чаддаг.

Жишээ болгон “97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд зөв, хурдан уншдаг” гэсэн шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг танилцуулъя.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН			
	I	II	III	IV
97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	90-ээс доош %-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” түвшинд зарим үгийн авиа үеийг буруу дуудан, эсвэл сольж хурдан уншдаг. Агуулгын 70%-ийн утгыг ойлгодог	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр авиа үеийг сольж гээлгүй, ярианы хурдаар уншин. Агуулгын 80%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.

Зөв, хурдан унших шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг боловсруулахдаа “Минутад зөв уншсан үгийн тоог нийт уншсан үгийн тоонд хувааж, алдаагүй унших түвшнийг тодорхойлдог дараах аргачлал дээр үндэслэсэн. Харин ойлгож унших шалгуурын гүйцэтгэлийг тусад нь түвшинчилснийг дэлгэрүүлэн хараарай.

Зөв уншилтын түвшин	Хувь
Чадварлаг	97-100%
Хангалттай	90-96%
Хангалтгүй	90%-ээс доош

Шалгуур тус бүрд сурагчдын гүйцэтгэлийг 4 түвшинд боловсруулсныг ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР-аас нягтлан харна уу.

Хүснэгт дэх мэдээллийг дэлгэрэнгүй тайлбарлая.

✓ **Үнэлгээг ямар зорилгоор хэрэглэх вэ?**

Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, сурагчдын мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшнийг ашиглах юм. “Үнэлгээний гол зорилго бол хүүхэд бүрийн хөгжлийн түвшнийг бодитой тодорхойлох, суралцахуйд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, багш нар суралцахуйг дэмжих сургалтын арга, технологийг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхэд оршдог.¹

✓ **Үнэлгээний нэгж гэдгийг хэрхэн ойлгох вэ?**

Үнэлгээний нэгжийн тухай ойлгохоос өмнө багш та бүхэн бага боловсролын монгол хэлний хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлан харах шаардлагатай юм.

✓ **Үнэлгээний нэгж, нэгж хичээл хоёр нэг зүйл үү?**

Үнэлгээний нэгжийг багш та бүхэн нэгж хичээлээс ялган ойлгох нь чухал юм. Нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг дидактик нэгжид хуваасан агуулгын хуваарилалт. Нэгж хичээлийг сургалтын хөтөлбөрөөс гадна сурах бичгийн агуулгад үндэслэн төлөвлөдөг. Нэг нэгж хичээлд унших, бичих, сонсох-ярих, хэлзүйг хэрэглэх гэсэн агуулга цогцоороо багтдаг. Зарим нэгжид сонсох-ярих, хэлзүйг хэрэглэх агуулгыг төлөвлөхгүй байж болно.

Харин үнэлгээний нэгж гэдэг нь хөтөлбөрийн үзэл баримтлалд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн агуулга буюу сурагчдын эзэмших чадваруудыг багцалж, суралцахуйн үр дүнд чиглэсэн агуулгын хуваарилалт. Нэгж хичээл шиг сурах бичгийн агуулгад үндэслэн төлөвлөөгүй, харин хөтөлбөрийн агуулгад үндэслэн үзэл баримтлалын хувьд хамгийн чухал ач холбогдолтойг тооцон томъёолсон.

✓ **Унших чадварыг хэрхэн үнэлгээний нэгж болгосон бэ?**

Унших чадварын үнэлгээний нэгжийг

1. Уншсанаа ойлгох
2. Уншсанаа бүтээлчээр ойлгох
3. Ойлгож, уран унших гэж 3 ангилсан. Энэ нь хөтөлбөрийн үндсэн зарчимтай холбоотой билээ.

Уншихын чадварыг “Эхийн агуулгыг ойлгох”, “Эхийн агуулгыг бүтээлчээр ойлгох” гэсэн 2 чиглэлээр үзэл баримтлалын хувьд ялган ойлгох нь чухал. Уншсан эхийн зөвхөн агуулгын хүрээнд ТООЧИХ, ТАЙЛБАРЛАХ, ЯЛГАХ, ХАРЬЦУУЛАХ, ДҮГНЭХ гэсэн оюуны үйлийг сурагч хийдэг. Үүн дээр үндэслэн “Уншсанаа ойлгох” гэж нэрлэн нэгжилсэн. Өөрөөр хэлбэл “Уншсанаа ойлгох” үнэлгээний нэгжийн хүрээнд сурагчид эх зохиолыг уншаад ойлгосныг, тоочсоныг, тайлбарласныг, ялгасныг, харьцуулсныг, дүгнэснийг үнэлнэ гэсэн үг юм.

Харин ТӨСӨӨЛӨХ, ТААМАГЛАХ оюуны үйл дээр үндэслэсэн унших чадварыг “Уншсанаа бүтээлчээр ойлгох” гэсэн үнэлгээний нэгжийн хүрээнд ойлгоно. Сайн таамаглаж байгаа сурагчийг үнэлэхдээ таамаглалаа үндэслэлтэй хэлж байна уу гэдгээр үнэлнэ. Сайн төсөөлж байгаа хүүхдийг өөрийнхөө оюуны дүр зургаар ургуулан бодож байгаа байдлаар үнэлнэ. Төсөөлөх, таамаглах гэсэн хоёр чадвар бол эхийг уншиж ойлгох БҮТЭЭЛЧ ЧАДВАР юм. Учир нь эхийг унших явцад хүүхэд тухайн эхийн баатар, баатрын үйл хөдлөлүүд, эхийн орчин зэргийг өөрийнхөө төсөөллөөр амилуулж боддогтой холбоотой юм. Өөрөөр хэлбэл тухайн эхэд бичигдээгүй утгыг хүүхэд өөрийнхөөрөө илэрхийлэн ярьж сэтгэх нь чухал юм.

Багш та унших чадварыг үнэлэх үнэлгээний даалгавар боловсруулахдаа суралцахуйн зорилтын ҮЙЛ ҮГ дээр үндэслэн зохиохыг зөвлөж байна. Хэддүгээр ангид унших чадварыг үнэлэхийг дараах хүснэгтээс харж болно.

Унших чадварын агуулгын залгамж холбооны гүнзгийрэл, чадваруудын ахиц²:

Анги		1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
Унших чадвар	Эхийн агуулгыг ойлгосноо харуулах	Ойлгох	Ойлгох	Ойлгох	Ойлгох	Ойлгох
		Тоочих	Тоочих Тайлбарлах	Тайлбарлах	Тайлбарлах	Тайлбарлах
				Ялгах	Ялгах	Ялгах
					Харьцуулах	Харьцуулах
					Дүгнэх	
	Эхийн агуулгыг бүтээлчээр ойлгох	Төсөөлөх	Төсөөлөх	Төсөөлөх	Төсөөлөх	Төсөөлөх
		Таамаглах	Таамаглах	Таамаглах	Таамаглах	
Танин мэдэхүйн түвшний хувьд	Доод түвшин	Доод түвшин	Доод түвшин	Доод болон дээд түвшин	Доод болон дээд түвшин	

Юуг хэрхэн ойлгох, юуг хэрхэн тоочих, юуг хэрхэн тайлбарлах, юуг хэрхэн ялгах, юуг хэрхэн харьцуулах, юуг хэрхэн дүгнэх, юуг хэрхэн төсөөлөх, юуг хэрхэн таамаглахыг “Сургалтын хөтөлбөр”-өөсөө суралцахуйн зорилт болсон томъёоллоос тодруулан хараарай. Ийнхүү суралцахуйн зорилтоо сайн ойлговол үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуурын томъёоллыг ойлгож, үнэлгээний даалгавар зөв боловсруулах юм.

Бичих чадварыг хэрхэн үнэлгээний нэгж болгосон бэ?

Бичих чадварын үнэлгээний нэгжийг


1. Зөв бичих

2. Зохион найруулан бичих гэж 2 ангилсан. Бичих чадвар гэдэг нь цээжээр зохион найруулан бичих үйлийг хэлнэ. Мөн техникийн хувьд зөв бичгийн дүрмийг баримтлан алдаагүй бичих, үг, өгүүлбэр, эхийг дэгийн дагуу зөв бичих нь чухал юм. Энэ нь бага боловсролын монгол хэлний хөтөлбөрийн үндсэн том зорилгын нэг болгон томъёолсон "Сурагч өөрийн бодол санаагаа амаар болон бичгээр илэрхийлэх чадвар"-тай холбоотой. Хүүхдийн санаа бодлыг нээх, илэрхийлэхэд зохион бичих үйл хамгийн их тусалдаг. Улсын шалгалт болон Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр авдаг “Чанарын үнэлгээ”-ний судалгаанд сурагчдын зохион бичих чадварыг илрүүлэх даалгаврууд тавигддаг бөгөөд сурагчдын гүйцэтгэл нь маш сул байгааг судалгааны дүн бидэнд мэдээлдэг билээ. Сургалтын хөтөлбөрт 1, 2 дугаар ангид багшийн хэлснийг цээжээр бичих, өгүүлбэр зохион бичих чадварыг үнэлэх зорилготой суралцахуйн зорилтыг төлөвлөн оруулснаас гадна 2 дугаар ангиас эхлээд эх зохион найруулан бичих чадварыг дэмжсэн суралцахуйн зорилтын тоог нэмснийг багш нар сайн мэддэг. Тэгэхээр үнэлгээний нэгжид багшийн хэлснийг цээжээр бичих гэхээсээ илүү өөрийн санаа бодлыг тусган цээжээр зохион найруулж бичихийг чухалд тооцсон болно. Улсын шалгалт болон “Чанарын үнэлгээ”-ний судалгаанд УНШААД ОЙЛГОХ ЧАДВАР, ЗОХИОН НАЙРУУЛЖ БИЧИХ ЧАДВАРЫГ хөгжүүлснийг үнэлдгийг багш бүр тооцон ажиллахыг хүсэж байна. Учир нь олон улсад ойлгох чадвар, зохион найруулах чадварыг хамгийн чухалд үздэгийг PISA-гийн шалгалтын материалаас харж болох юм.

Сонсох-ярих чадварыг хэрхэн үнэлгээний нэгж болгосон бэ?

Сонсох-ярих үйл нь хүүхдийн багаар ажиллах, харилцах чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг болох учиртай. Харин яаж сонсох, яаж ярихыг сургалтын хөтөлбөрт туссан агуулгын залгамж холбоонд нь сайтар судлахыг хүсэж байна. Бид үнэлгээний нэгжийг дараах байдлаар багцалсан юм.

² П.Одсүрэн, “Бага ангийн багш нарт” бага боловсролын монгол хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж”, Уб., 2020 он, 14-р тал



Хэлзүй, үгийн санг хэрэглэх чадвар буюу 4 гэсэн кодтой суралцахуйн зорилтуудыг үнэлгээний нэгж болгоогүйн учир нь монгол хэлний хөтөлбөрийн үзэл баримтлалтай холбоотой юм. Тодруулбал, уламжлалт хэл шинжлэлд хэл зүйг, хэл зүйн мэдлэгийг чухалчилж, тодруулбал авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, эхийн тухай ухагдахууныг мэдлэг болгон эзэмшүүлэх замаар хэлийг хэрэглээнд нь авч үздэггүй байсан бол энэ удаагийн хөтөлбөрийн шинэчлэлээр мэдлэгээ хэрхэн хэрэглэх арга, аргачлалыг дэвшүүлэн тавьсан онцлогтой холбож ойлгохыг зөвлөж байна. Иймээс хэлзүйг хэрэглэхтэй холбоотой суралцахуйн зорилтуудыг бичих чадварыг хөгжүүлэх үнэлгээний нэгжийн үр дүн, шалгууртай холбон үнэлгээний даалгавар боловсруулна уу.

Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнг хэрхэн ойлгох вэ?

“V ангийн МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛЭЭР сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн, түүний шалгуур” гэсэн хүснэгтийг дахин хараарай. Харахдаа үнэлгээний нэгж бүрийн суралцахуйн үр дүнг хэрхэн томъёолсныг ажиглана уу. СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГ томъёолохдоо дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Хэд хэдэн суралцахуйн зорилтуудыг нэгтгэж, ерөнхийлсөн.
2. Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалтын хувьд, хүүхдийн насан туршийн боловсролын суурь чадвар болохынхоо хувьд өргөн хүрээний, хамгийн чухал хэмээн үзэж байгаа мэдлэг, чадвар, хандлагыг сонгон суралцахуйн үр дүнгээ томъёолсон.

Тухайлбал, “Уншсанаа ойлгох” үнэлгээний нэгжийн хүрээнд хүүхэд дараах 2 үр дүнд хүрнэ.

- A. Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншдаг болно.
- B. Сурагч эхийг зөв, хурдан ойлгож уншаад, уншсан зүйлээ тайлбарлаж, ялгаж, харьцуулж, дүгнэж чаддаг болно.

Эдгээрээс эхний үр дүнг тайлбарлая. “Зөв унших нь авиаг зөв дуудахаас, хурдан унших нь зөв уншихаас, ойлгож унших нь хурдан уншихаас шууд хамааралтай”³-г тодруулсан “Унших чадварын үнэлгээ”-ний судалгаа (EGRA)-н дээр үндэслэсэн болно. Авиа, үсгийг зөв дуудаж унших, хурдан уншихдаа ойлгох нь уншлагын чанарыг илтгэдэг. Хурдан унших гэдэг нь ярианы хурдаар, бүтэн үгээр унших чадварыг хэлнэ. Хурдан уншдаг хүүхдийн ойлгоц нь сайн байдаг. Хэт удаан унших, ярианы хурдтай тохируулж уншдаггүй хүүхэд эхийн утгыг ойлгодоггүй. Авиа, үсгийг буруу дуудсанаас, үсэг, үеийг сольж хэлснээс, амьсгаагаа тохируулаагүйгээс шалтгаалж эхийн утгыг ойлгохгүй асуудал гардаг. Иймээс ОЙЛГОЖ унших чадварыг хөгжүүлэхдээ ЗӨВ, ХУРДАН, ОЙЛГОЖ унших гэсэн шаардлагуудыг багш бүр анхаарч, сурагчаа хөгжүүлэхийг энэхүү СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН чиглүүлж байна. Зөв бөгөөд хурдан, ойлгож унших нь суурь чадвар юм гэж үзэж байгаа учраас суралцахуйн үр дүн болгож томъёолсон нь ийм учиртай. Жил, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлтийг боловсруулахдаа зөв, хурдан, ойлгож уншдаг арга барилыг эзэмшүүлэх, түүнийг үнэлэхэд голлон анхаарах юм.

Үнэлгээний шалгуурыг жил, нэгж, ээлжит хичээлийн гараа, явц, үр дүнгийн үнэлгээнд хэрхэн хэрэглэх арга зүйн зөвлөмж

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг жил, нэгж, ээлжит хичээлийн (гараа, явц, үр дүнгийн) үнэлгээнд хэрхэн хэрэглэх вэ?

Сурагч өөрийгөө сурсан гэдгийг яаж мэдэх вэ? Суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд юу хийж чаддаг болсон байх вэ?

Үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа юуг, хэрхэн, яаж үнэлэхийг тодруулсан билээ. Ингэхдээ суралцахуйн зорилт бүрийн агуулгын мөн чанарыг алдагдуулахгүйгээр, нөхцөл, гүйцэтгэл, шалгуурыг тодруулах замаар нарийвчлан боловсруулсан учраас багш та бүхэн суралцахуйн зорилт болон үнэлгээний шалгуур хоёрыг харьцуулан судлах нь чухал.

“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д үнэлгээний дараах гурван төрлийг суралцагчийн үнэлгээнд хэрэглэхээр⁴ тусгасан.

Үнэлгээний төрөл	Гарааны буюу оношлох үнэлгээ	Явцын үнэлгээ	Үр дүнгийн үнэлгээ
Хэзээ үнэлэх вэ?	Хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө	Ээлжит хичээл, сургалтын явцад тогтмол хийх	Бүлэг сэдэв, хагас жил, хичээлийн жилийн эцэст
Ямар зорилгоор үнэлэх вэ?	Суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тандах зорилгоор	Суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор	Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг хэмжих зорилгоор
Хэддүгээр ангид үнэлэх вэ?	III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.	I, II ангид оношлох болон явцын үнэлгээний төрлийг ашиглана.	III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.
Үнэлгээний ямар хэлбэрийг ашиглаж болох вэ?	<ul style="list-style-type: none"> Ажиглалт Ярилцлага Хэлэлцүүлэг Асуулт Сорил Судалгаа 	<ul style="list-style-type: none"> Ажиглалт Асуулт Хэлэлцүүлэг Ярилцлага Бие даах ажил Рубрик Суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ г.м 	<ul style="list-style-type: none"> Аман Бичгийн шалгалт Сорил, туршилт Судалгааны ажил Тайлан Төсөлт ажил Илтгэл Эсээ Бүтээл Биечлэн хийж гүйцэтгэх

Үнэлгээний шалгуурыг жилийн төлөвлөлтөд хэрхэн хэрэглэх вэ?

Боловсролын хүрээлэнгийн “Сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа” (2019 он)-нд жилийн төлөвлөлтөд агуулгаа хуваарилахаас гадна жилийн үнэлгээг тусгах асуудлыг хөндсөн билээ. Жилийн үнэлгээнд “үр дүнгийн үнэлгээ”-г тусгана.

Жилийн төлөвлөлтөд үнэлгээний шалгуурыг тусгахдаа сургалтын хөтөлбөр дэх үнэлгээний шалгуурыг баримтална. Сургалтын хөтөлбөрийн зорилт нь мэдлэг, мэдлэгээ хэрэглэх буюу чадвар, хандлага гэсэн гурван чиглэлээр тодорхойлогдсонтой холбоотойгоор үнэлгээний зорилт нь мөн адил мэдлэг, чадвар, хандлагыг үнэлнэ. Иймээс жилийн туршид сурагч юуг мэддэг болох вэ, юуг чаддаг болох вэ, ямар хандлагатай болох вэ гэдгийг улирлаар нь юм уу, бүлэг сэдвээр нь хуваан тодруулна. Бага боловсролын монгол хэлний хичээлийн агуулгыг нэгжийн түвшинд боловсруулдаг учраас хэчнээн нэгж хичээлийн дараа мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхийг багш тооцож боловсруулах учиртай. Дараах загварыг санал болгож байна. Тухайн загварыг өөрийн сургуулийн менежментийн түвшинд өөрчлөх эрх та бүхэнд бий.

.... дугаар (3, 4, 5) ангийн жилийн төлөвлөлтийн жишиг загвар

Жилийн төлөвлөлтийн зорилго:

.....

.....

Улирал		I улирал	II улирал	III улирал	IV улирал	Үр дүнгийн буюу жилийн эцсийн үнэлгээ хийнэ.
Цагийн хуваарилалт						
Нэгжийн сэдэв						
Жилийн төлөвлөлтийн зорилт	Эзэмших мэдлэг	Нэгж тус бүрд эзэмших мэдлэгийг бичнэ.				
	Эзэмших чадвар	Нэгж тус бүрд эзэмших чадварыг бичнэ.				
	Хандлага	Нэгж тус бүрд байхаар хандлагыг тодорхойлж бичнэ.				
Суралцахуйн зорилт, код						
Үнэлгээний зорилт	Эзэмших мэдлэг	Хагас жилд үнэлэх мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно.		Хагас жилд үнэлэх мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно.		
	Эзэмших чадвар					
	Хандлага					
Үнэлгээнд хэрэглэх хэлбэр, арга хэрэгсэл		Үнэлгээний журмыг судална уу.				

Анхаарах зүйл:

- Хэд хэдэн нэгжийн агуулгыг судалсны дараа буюу хагас жил, мөн жилийн эцэст "Үр дүнгийн үнэлгээ" хийнэ. Үр дүнгийн үнэлгээнд "уншсанаа ойлгох, уншсанаа бүтээлчээр ойлгох, ойлгосноо уран унших, зөв бичих, зохион найруулж бичих, бусдыг ойлгож, хүндэтгэн сонсон, зөв харилцах" гэсэн үнэлгээний нэгжийн нэршлийн цаадах мөн чанарыг хамгийн чухал гэж үзэж, тэрхүү үзэл баримтлалаар асуудалд хандан үнэлгээ хийхийг зөвлөж байна. Жилийн эцсийн үнэлгээний даалгавар боловсруулахдаа улсын шалгалт болон чанарын үнэлгээний даалгаврын жишгээр боловсруулж болно.
- "Монгол хэлний хичээлийн сургалтын үр дүнг үнэлэх шалгуур" (2021 он) гэсэн бүтээгдэхүүний "Сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн" дээр суурилан үр дүнгийн үнэлгээг боловсруулна. Тухайлбал, 5 дугаар ангийн сурагч юу хийж чаддаг болохыг дараах үр дүн дээр тулгуурлан үнэлгээний даалгавар боловсруулна.
 - Сурагч эхийн утгыг ойлгож, зөв хурдан уншдаг болно.
 - Сурагч эхийн утгыг ойлгож уншаад, уншсан зүйлээ тайлбарлаж, ялгаж, харьцуулж, дүгнэж чаддаг болно.
 - Зохиолыг унших явцад төсөөлж, таамаглах чадвараа харуулна
 - Зөв бичих дүрмийг мэдэж, зохион найруулж бичихдээ алдаагүй зөв бичиж сурна
 - Сурагч өгөгдсөн бүтцийн дагуу эх зохиож, товчилж, ятгаж, илэрхийлж найруулж бичиж чаддаг болсон байна. /богино өгүүллэг, захидал, өдрийн тэмдэглэл, мэдээ, харилцан яриа, оньсого, үлгэр/

Харин сурагч хэрхэн хийж чадаж байгааг нарийвчлан үнэлэхдээ үнэлгээний шалгуурыг нь тодруулж харах юм.
- Тухайн ангид хэчнээн нэгж хичээл судлахыг сурах бичгийн эхний нүүрт буй агуулгын матрицаас харна.
- Монгол хэлний хичээлээр ямар мэдлэгтэй болох вэ гэдгийг сургалтын хөтөлбөрт А1, А2 гэсэн кодоор илэрхийлсэн. Тодруулбал,
 - Үг, өгүүлбэр, эхийн утга, бүтэц, зүй тогтол, үгийн сан, хэлний хэрэглээ
 - Зөв бичгийн дүрмийн мэдлэг гэсэн нь бий. Тиймээс тухайн ангид ямар зөв бичгийн дүрэм үзэж судалснаас шалтгаалж мэдлэгийг тогтооно. Мөн шинэ үгийн мэдлэг, үгийн утга, өгүүлбэрийн утга, эхийн утгын талаарх мэдлэг, үйл явдал, түүний дараалал, цогцолбор, догол мөр, эхийн бүтэц буюу эхлэл, гол, төгсгөл хэсгийн тухай мэдлэг, хэлц үгийн тайлбарын тухай мэдлэг /2, 3-р анги/, хэлц үгийн тухай мэдлэг /4, 5-р анги/, ойролцоо утгатай үг, эсрэг утгатай үг, анхааруулах, хүүрнэх, асуух өгүүлбэрийн тухай мэдлэг гэх мэт мэдлэгийг эзэмшсэн байхаар тооцож төлөвлөнө. Энэ мэтчилэн Б гэж томъёолсон чадвар, В гэж томъёолсон хандлагыг багш бүр сургалтын хөтөлбөрөөсөө судлаарай.

Үнэлгээний шалгуурыг нэгжийн төлөвлөлт болон оношлох үнэлгээнд хэрхэн хэрэглэх вэ?

Нэгж хичээлийн төлөвлөлтөд оношлох үнэлгээний төрлийг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл нэгж хичээлийн өмнө болон дараагийн нэгж хичээл эхлэхийн өмнө сурагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлнэ. Оношлох үнэлгээ нь сурагчдын ялгаатай байдлыг тодруулахад их ач холбогдолтой. Учир нь нэгжээс дараагийн нэгжид үнэлгээ хийж байгаатай холбоотой.

Нэгжийн төлөвлөлт нь монгол хэлний хичээлийн хувьд өвөрмөц бүтэцтэй байдаг. Ялангуяа нэгж хичээлийн АГУУЛГЫН ТӨЛӨВЛӨЛТ-д унших, бичих, сонсох-ярих, хэл зүй, үгийн санг хэрэглэх чадваруудыг интеграц болгон төлөвлөдөг.

Нэгж хичээл бүр дээр давтан үнэлэх шалгуур бий. Тухайлбал, зөв, хурдан, ойлгож унших чадварыг үнэлэхэд чиглэсэн “97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд зөв, хурдан уншдаг” гэсэн шалгуурыг багш бүр нэгж хичээлийн өмнө болон дараа нь үнэлэхээр оруулж ажиллахыг санал болгож байна.

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

Монгол хэлний хичээлийн нэгжийг төлөвлөхдөө ялангуяа нэгж хичээлийн АГУУЛГЫН ТӨЛӨВЛӨЛТ-д унших, бичих, сонсох-ярих, хэл зүй, үгийн санг хэрэглэх чадваруудыг интеграцилдаг. Учир нь ямар эхийг зохион найруулж бичихээс шалтгаалж, холбогдох унших чадвар буюу суралцахуйн зорилтыг сонгон авч, интеграцилна. Жишээ нь, “Адил төстэй шинжийг харьцуулан, утгыг далдлан оньсого зохион бичих” 5.2к гэсэн бичих чадварыг “Оньсогоын далд утгыг үндэслэлтэй таамаглах” 5.1л гэсэн унших чадвартай интеграцилна. Үлгэр зохиож бичнэ гэсэн бол үлгэр уншихтай холбох, жүжгийн харилцан яриа нэмж бичих бол жүжгийн хэсгээс уншуулах гэх мэтээр. Ийм зарчмаар нэг нэгжийг сонгон үнэлгээний даалгаврын жишээг, аргачлалын хамт танилцуулъя. Гэхдээ энэ хэсэгт нэгж хичээлийн төлөвлөлтийг цогцоор нь хийхийг зорьсонгүй, зөвхөн сэдэв, зорилго, зорилт, үнэлгээний төлөвлөлт гэсэн хэсгийг оруулсан болно.

Нэгжийн сэдэв: Үлгэр зохиоё.

Нэгжийн зорилго: Үлгэрийн утгыг ойлгож, ойлгосноо жүжиглэж харуулахаас гадна хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлаж сурснаар үлгэрийг дэгийн дагуу зохион, зөв алдаагүй бичих арга барилтай болно.

Нэгжийн зорилт:

Мэдлэг			
А1. Өгүүлбэрийн утга, эхийн утга			
Чадвар			
Унших чадвар	Бичих чадвар	Сонсох-ярих чадвар	Хэл зүйг хэрэглэх чадвар
Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д	Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох 5.2м	Зохиолын баатрын хэл яриа, үйл хөдлөлийг дуурайн, үзэл бодлыг илэрхийлэн жүжиглэх 5.3г	Хашилт тэмдгийг зөв хэрэглэн өгүүлбэр зохиох 5.4а
Хандлага			
В. Дүрд тоглохдоо чармайн мэрийж байгаа байдал			

Үнэлгээний төлөвлөлт:

Суралцахуйн зорилт	Үнэлгээний шалгуур	Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
“Зөв, хурдан, ойлгож унших чадварын шалгуур (Нэгж бүр дээр үнэлэх шалгуур)	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	90-ээс доош %-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” түвшинд зарим үгийн авиа үеийг буруу дуудан, эсвэл сольж хурдан уншдаг. Нийт агуулгын 70%-ийн утгыг ойлгодог	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр авиа үеийг сольж гээлгүй, ярианы хурдаар уншин, нийт агуулгын 80%-ийн утгыг ойлгодог.	90-96%-ийн гүйцэтгэлтэй буюу “хангалттай” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулж уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.	97-100%-ийн гүйцэтгэлтэй буюу “чадварлаг” түвшинд бүтэн үгээр, ярианы хурдаар, амьсгалаа тохируулан зөв, хурдан уншиж, агуулгыг бүрэн ойлгодог.
Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг	Амьтдын хэлсэн үгийг ялган таньдаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үгээс нь жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг
Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох 5.2м	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, нөхцөл байдал, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа ойлгомжтой, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв бичиж илэрхийлдэг	Үлгэр зохиохдоо үйл явдлыг дарааллуулан тоочиж, ойлгомжтой бичиж илэрхийлдэг	Үлгэр зохиохдоо үйл явдлыг дарааллуулан тоочиж, ойлгомжтой, алдаагүй зөв илэрхийлдэг	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа ойлгомжтой, алдаагүй бичиж илэрхийлдэг	Үлгэр зохиохдоо эхлэл хэсэгт дүр, нөхцөл байдал, орчноо танилцуулан, гол хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, боломжийг өрнүүлэн, төгсгөл хэсэгтээ асуудлыг шийдвэрлэсэн санаагаа ойлгомжтой, цогцолборуудыг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, алдаагүй, зөв бичиж илэрхийлдэг
Зохиолын баатрын хэл яриа, үйл хөдлөлийг дуурайн, үзэл бодлыг илэрхийлэн жүжиглэх 5.3г	Үгийн утгыг мэдэрч, зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглон, уран уншдаг	Дуу хоолойны өнгөө тохируулан уран уншдаг	Зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, айзам хэмнэлийг тохируулан дүрд тоглон, уран уншдаг	Үгийн утгыг мэдэрч, зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэлээ тохируулан, дүрд тоглон, уран уншдаг	Үгийн утгыг мэдэрч, зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан дүрд тоглон, уран уншдаг

Хашилт тэмдгийг зөв хэрэглэн өгүүлбэр зохиох 5.4а	Энэхүү суралцахуйн зорилтыг үлгэр зохион бичих ээлжит хичээл дээр шалгуур болгон хэрэглэнэ.
---	---

Дээрх хүснэгтийн эхний хоёр баганад суралцахуйн зорилт болон түүний шалгуурыг бичсэн байна. Нэгж хичээлийн ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ-ийг боловсруулахдаа суралцахуйн зорилт буюу тухайн чадварыг эзэмшихийн тулд сурагч ямар шалгуурыг хангаж суралцах вэ гэдгийг тооцно. Иймд сурагчдын унших, бичих, сонсох-ярих, хэлзүйг хэрэглэх чадварыг үнэлэхдээ шалгуур дээр үндэслэх учиртай юм.

Уншаад ойлгох болон хэлний зүйн мэдлэг ойлголтыг үнэлэхдээ сонгох хариулттай тест буюу сорилоор, харин уншаад тайлбарлаж бичих, уншаад ялгах, уншаад харьцуулах, уншаад дүгнэж бичих зэрэг чадварыг, түүнчлэн зохион бичих чадварыг хэрхэн хөгжүүлснийг задгай хариулттай даалгавраар шалгаж болно. Жишээ болгон, дээрх нэгжийн зорилт болон үнэлгээний төлөвлөлтөд туссан суралцахуйн зорилтыг үнэлэх даалгавар танилцуулъя. Даалгаврын үнэлгээний зорилт нь тухайн нэгжийн зорилт болон үнэлгээний зорилттой МЭДЛЭГ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГЭЭ ХЭРЭГЛЭХ ЧАДВАР, ХАНДЛАГА гэсэн бүтцээрээ ижил юм.

Нэгж хичээлийн оношлох үнэлгээний даалгавар

1. Эхийн утгыг ойлгож, зөв, хурдан уншаарай

УХНА ГУАЙ

Урьд нэг айлд омог бардам ухна байжээ. Ухна гуай өөрийн сүргийн төлөө ер санаа үл тавин, ганцхан өөрийн биеийн жаргалыг эрхэмлэдэг байжээ.

Нэгэн өвлийн янгинам хүйтэн шөнө тэнгэр зузаан үүлээр бүрхэгдэж, сүрхий хүчтэй цасан шуурга болоход өнөө эвэр ихт ухна бусад хонь ямааг айлган, хурц үзүүртэй эврээр мөргөн хөөж босгосоор хамгийн аятай дулаан газрыг эрж явлаа.

Тэгж явсаар хуц гуайн дэргэд очиж гэнэ. Ухна “ихэмсэг зангаас минь хуц айж, тухтай дулаахан байраа найр тавин өгч, өөр газар очих биз” гэж боджээ. Гэтэл өнөө хуц ер ажиглан анхаарсан шинжгүй, тухлаг хэвтэртээ тавтай хэвтээд зүүрмэглэн байхаар нь ямаан сүргийн тэргүүн ухна гуай омог уур ихэд хүрч, дээш цоройн сүрийг бадруулан, хуцыг мөргөө гээд цоройх гэтэл хашаатай олон хонь ямаа тал талаас шахах учир үл айгч хуцыг мөргөж чадсангүй. Хий л уур омог нь хүрч цухалдан дараа нэг чадал хүчээ үзүүлье гэж бодсоор өөр тухтай байр олохоор хавь ойрын бусад хонь ямааг айлгаж, тав тухыг нь алдуулан хашаан дотуур цааш явжээ.

Тэр хашааны нэгэн буланд хонин сүргийн дунд хамгийн их настай хөгшин ирэг хэвтэж байжээ. Ухна гуай уурандаа хөгшин иргийг айлгаж, босгон хөөгөөд, унтаж, цасан шуурганы аюулыг мэдэрсэнгүй. Гэтэл шуурганаар хоол эрж явсан өлөн чоно хотонд сэмхэн орж, нэгэн ямааны сүвээнээс үмх мах тасдан авсан нь дээрэнгүй зант ухных байжээ...

Маргааш өглөө бэлчээрт гарахад ухнын шарх ихэд өвдөж, хэвтэн босон, байж ядан, зовуурилан шаналахад ижил олон сүргээс нэг нь ч ухныг өрөвдөн хайрласангүй гэнээ...

(Монгол ардын үлгэр, Д.Цэрэнсодном,

“Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг” 2011 он, 483 дугаар тал)

2. Зөв, хурдан уншсанаа үнэлээрэй.

Зохиолын нийт үг	233
Минутад уншсан үгийн тоог тэмдэглээрэй.	Хэдэн үг вэ?
Ямар нэгэн үгийн авиаг зөв дуудаагүй бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ?
Ямар нэгэн үгийн үсгийг сольж хэлсэн бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ?
Ямар нэгэн үгийн үеийг сольж хэлсэн бол тухайн үгээ хасаарай.	Хэдэн үг вэ?
Ямар нэгэн үгийг бүтэн биш, авиа үсгийг хэлээгүй бол тухайн үгээ хасаарай.	
Ярианы хурдаар биш, хэт хурдан буюу амьсгалаа зөв тохируулаагүй уншсан бол дараагийн удаа анхаараарай.	
	Буруу уншсан үгийн тоо
	Засаж уншсан үгийн тоо
	Зөв уншсан үгийн тоо
	Уншлагын хувь
	Уншлагын түвшин

Зөв, хурдан унших чадварыг үнэлэх аргачлал:

Зөв уншилтыг тооцохдоо 1 минутад уншсан зөв үгийн тоог нийт уншсан үгийн тоонд хувааж гаргана. Дараагийн хүснэгтэд алдаатай уншсан үгээ тэмдэглээрэй. Жишээ нь, хэрвээ 12 үгийг дараах байдлаар алдаж, хасалт гэж тэмдэглэсэн бол нийт 105 үгээс 97 үгийг зөв уншсан гэж тооцно. Дараа нь 97 үгээ нийт уншсан 105 үгийн тоонд хуваагаад, зөв уншилтаа үнэлээрэй. 97-100% оноо авсан бол “Чадварлаг түвшинд”, 90-96%-ийн оноо авсан бол “Хангалттай түвшинд”, 90%-иас доошоо үнэлэгдсэн бол “Хангалтгүй түвшин”-д зөв хурдан уншдаг юм байна гэж үнэлээрэй.

Мэдлэг үнэлэх зорилготой сонгох даалгавар

- Ямар зантай ухна байсан бэ? Зөв хариултыг сонгоорой.
 - А. Омог, бардам
 - Б. Омог, шартай
 - В. Бардам туулай шиг
 - Г. Өөрийгөө хайрласан
- Ухна гэдэг амьтныг хүн шиг бодож, хүн шиг аашилдаг гэж бичсэн үү?
 - А. Тийм
 - Б. Үгүй
- Дараах дөрвөн амьтны хийсэн үйлдлийг зөв харгалзуулна уу.

Ухна	Хашааны буланд хэвтэж байсан
Хуц	Ямааны сүвээнээс үмх мах тасдан авсан
Ирэг	Тухлаг хэвтэртээ тавтай хэвтэж байсан
Чоно	Хурц үзүүртэй эврээр мөргөн хөөсөн
- Ижил олон сүрэг нь ухныг яагаад өрөвдөж хайрласангүй вэ? Зөв хариултыг сонгоорой.
 - А. Ухна ижил олон сүргээсээ өөр газар амьдардаг байсан учраас
 - Б. Ухна ижил олон сүрэгтээ дээрэнгүй ханддаг байсан учраас
 - В. Ижил олон сүрэг нь өрөвдөх сэтгэлгүй болохоор
 - Г. “Ухна бол ямаан сүргийн тэргүүн” гэж тэд бодсон

Сонгох даалгавар боловсруулах аргачлал:

1. Сонгох даалгаврын өмнө ЗӨВ, ХУРДАН унших чадварыг үнэлэх аргачлал, тэмдэглэх хуудсыг оруулсан. Аливаа нэгжийн төлөвлөлтөд суралцахуйн зорилтуудаас гадна зөв, хурдан унших чадварыг үнэлэх хэсэг оруулж байхыг зөвлөж ийн орууллаа. Хэрвээ 2 дугаар ангиасаа зөв, хурдан унших чадварыг хөгжүүлсэн байвал заавал 5 дугаар ангид байнга үнэлэхээр тусгах албагүй юм.
2. Сонгох даалгавар нь мэдлэг, ойлголтыг үнэлдэг. Нэгжийн төлөвлөлтөд юуг мэдлэг гэж төлөвлөснөө харна. Дээрх нэгжид сургалтын хөтөлбөрийн 24-р талд буй “А1 буюу өгүүлбэр, эхийн утга” гэж төлөвлөснийг үндэс болгож, уншиж ойлгосныг үнэлэхийг зорьсон байна. Харин А1-ээ сургалтын хөтөлбөрөөсөө хэрхэн сонгохоо багш сурагчдынхаа өмнөх төсөөлөл, өмнөх нэгж дээр оношилсон судалгаанаас шалтгаалж, шийднэ. Хэрэв өмнөх нэгж дээр ангийн сурагчдын ихэнх нь эх уншаад, өгүүлбэр, эхийн утгыг ойлгох чадвар тааруу гүйцэтгэлтэй байвал энэ мэтээр даалгаврыг боловсруулна гэсэн үг.
3. Сонгох даалгаврын дасгал бүрийн зорилго юу вэ гэдгийг эргэцүүлэн зохионо. Хөтөлбөрийн агуулгатай уялдаатай байгаа эсэх, мэдлэг эзэмшүүлж байгаа эсэхийг сайтар төлөвлөөрэй.
4. Сонгох даалгавар олон төрлөөр боловсруулдаг. Бид энэ нэгж дээр СОНГОХ, ХАРГАЛЗУУЛАХ, ТИЙМ/ ҮГҮЙ гэсэн 3 хувилбараар зохиолоо.
5. Даалгавар бүрт хэр хугацаа шаарддагийг тооцно.
6. Сонгох даалгавар бүрт 1 оноо өгнө. Ер нь 1-2 оноо байхыг зөвлөдөг аж. Жигд оноотой байх нь анхны онооны тархалтад эерэг нөлөөтэй гэж үздэг юм байна.

Асуулт (даалгавар)-ын төрөл ⁵	Шаардлагатай тойм хугацаа
Зөв буруу 2 сонголттой асуулт	20-30 секунд
Олон сонголттой (баримтад суурилсан)	40-60 секунд
Нэг үгээр нөхөх	40-60 секунд
Олон сонголттой (нийлмэл)	70-90 секунд
Харгалзуулах (5-6 сонголт)	2-4 минут
Товч хариулт	2-4 минут
Олон сонголттой (тооцоололтой)	2-5 минут
Өгүүлбэртэй бодлого (энгийн арифметик үйлдэлтэй)	5-10 минут
Богино эсээ бичлэг	10-20 минут
Өгөгдөл (график)-ийн шинжилгээ	15-25 минут
Загвар зурах/нэр томъёо бичих	20-30 минут
Дэлгэрэнгүй эсээ бичлэг	35-50 минут

Чадварыг үнэлэх зорилготой задгай даалгавар:


1. Ухнын бодсон бодлыг ялгаад, нөхөн бичнэ үү.
Ухна хуц гуайн дэргэд очоод” гэж боджээ.
2. Ухнын хийсэн үйлийг ялган бичнэ үү.
.....
.....
.....
3. Бодсон бодол, хийсэн үйлдлээс нь ямар хүний зан чанарыг бичсэн бэ? Оновчтой жишээ татан тайлбарлан бичээрэй.
.....
.....
.....

⁵ Эх сурвалж: Антони Ж.Нитко ба бусад. Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх арга зүй, хуудас 123-150 дугаар талд

4. Тусархаг, өрөвч зөөлөн зан чанартай нэгэн амьтны тухай үлгэр зохиогоорой. Зохиохдоо баатрын бодсон бодол, хийх үйлдлийг тодорхой бичээрэй. (80-100 үг)

Задгай даалгавар боловсруулах аргачлал:

1. Суралцагчаас дэвшүүлсэн асуултад чөлөөт байдлаар хариулахыг шаарддаг бөгөөд танин мэдэхүйн түвшний хувьд сэргээн санах, ойлгох чадвараас илүү дээд түвшний чадварыг үнэлэхэд чиглэсэн байдаг. Иймээс “Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д” суралцахуйн зорилтыг сонгон даалгавар боловсруулсан.
2. Нэгжийн ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨӨ харах, харахдаа суралцахуйн зорилтын үйл үгийг ажиглаж, дээд түвшний үйл шаардахаар байна уу, доод түвшний үйл шаардахаар байна уу гэдгийг тооцож, задгай хэлбэрийн даалгавар эсвэл сонгох хэлбэрийн даалгавар болгохыг шийднэ. “5.1д”-д “тайлбарлах” гэсэн дээд түвшний үйл шаардаж байгаа учраас задгай хэлбэрээр бичүүлж авч байна. Өөрөөр хэлбэл даалгаврын зорилго нь “тайлбарлах” чадварыг үнэлэхэд чиглэгдэж байна.
3. Дараах төрлийг хэрэглэж боловсруулна. Энэхүү нэгжид нөхөх, богино болон дэлгэрэнгүй хариулттай бичих төрлийг сонгов.



4. Задгай даалгаврын оноожилтыг 1-5 оноо /10 хүртэл/ байхуйцаар төлөвлөнө.

Сонсох-ярих чадвар болон хандлагыг үнэлэх зорилготой даалгавар (Рубрик)

Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин	Өөрийн болон багшийн үнэлгээ
5 оноо	Үгийн утгыг мэдэрч, зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэл, зогсоц, өргөлт, хурд, нүүрний хувирлаа тохируулан чармайн мэрийн дүрд тоглон, уран уншдаг	
4 оноо	Үгийн утгыг мэдэрч, зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, биеийн хөдөлгөөн, айзам хэмнэлээ тохируулан, чармайн мэрийн дүрд тоглон, уран уншдаг	
3 оноо	Зохиолчийн санааг ойлгосны үндсэн дээр дуу хоолойны өнгө, айзам хэмнэлийг тохируулан чармайн мэрийн дүрд тоглон, уран уншдаг	
2 оноо	Дуу хоолойны өнгөө тохируулан уран уншдаг	

Үнэлгээний шалгуурыг ээлжит хичээлийн төлөвлөлт болон явцын үнэлгээнд хэрхэн хэрэглэх вэ?

Ээлжит хичээлийн төлөвлөлтөд явцын үнэлгээний төрлийг хэрэглэнэ. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.⁶ Харин 3,4,5 дугаар ангид үнэлгээний шалгуурыг ээлжит хичээлийн явцын үнэлгээнд хэрэглэнэ. Нэгжийн төлөвлөлтөө ялангуяа нэгжийн үнэлгээний төлөвлөлтөө дээрх байдлаар харж төлөвлөвөл ээлжит хичээл дээр ямар шалгуур хэрэглэх нь ойлгомжтой болох юм. Жишээ нь дээрх нэгжээс “Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д” гэсэн нэг суралцахуйн зорилтыг эзэмшүүлэх зорилготой ээлжит хичээлийг сонгоё.

Сэдэв: Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д	Хичээлийн зорилго: Уншсан эх дэх хүншүүлсэн дүрслэлийг оновчтой жишээ татан тайлбарлан бичнэ.
Суралцахуйн зорилт:	Гүйцэтгэл нь: Сурагч утгыг ойлгоно Нөхцөл нь: Үлгэр дэх дүрслэлээс Шалгуур нь: хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлаж
Үнэлгээний шалгуур:	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг

Үнэлгээг 4 шатлалтай авч үзсэн нь сурагчийн мэдлэг, чадварын ахиц өөрчлөлтийг хянах, амжилтаа ахиулах буюу түвшнээ ахиулах боломжийг олгохтой холбоотой юм. Сургалтын явцад “Би хаана байна вэ?” гэж сурагч өөрийнхөө түвшнийг харах, хянах боломжийг энэхүү 4 түвшин тусална. Явцын үнэлгээ нь сурагчийг хэрхэн суралцаж буйтай холбоотой мэдээлэл цуглуулах зорилготой бөгөөд харин багш түүнд үндэслэн арга зүйгээ тохируулах боломжтой.

Үнэлгээний төлөвлөлт:

Суралцахуйн зорилт	Үнэлгээний шалгуур	Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг	Амьтдын хэлсэн үгийг ялган таньдаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үгээс нь жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг

⁶ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралт

Гурав.Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

“Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д” суралцахуйн зорилт буюу энэхүү чадварыг хэрхэн эзэмшсэнийг ямар шалгуураар үнэлэх вэ гэдэг нь их чухал юм. Өөрөөр хэлбэл сайн тайлбарлаж байгаагийн шалгуур нь юу вэ гэдгийг багш та бүхэн бидний боловсруулсан ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРААС харахад болно. Нэгжийн ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ-д суралцахуйн зорилтын шалгуур болон гүйцэтгэлийн түвшнийг хүснэгтээр үзүүлснийг дахин харъя.

Үнэлгээний төлөвлөлт:

Суралцахуйн зорилт	Үнэлгээний шалгуур	Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Эхээс хүншүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах 5.1д	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг	Амьтдын хэлсэн үгийг ялган таньдаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үгээс нь жишээ татан тайлбарладаг	Хүний зан чанарыг амьтдын дүрээр гаргасныг хэлсэн үг, бодсон бодол, хийсэн үйлдлээс нь оновчтой жишээ татан тайлбарладаг

Энэхүү гүйцэтгэлийн түвшин дээр үндэслэн даалгавраа зохиосныг нэгжийн үнэлгээний даалгавраас харна уу. Тодруулбал, гүйцэтгэлийн түвшин болон шалгуурыг даалгаврын тавилд тусгах нь эргээд сурагчийг хийж гүйцэтгэсний дараа 4 түвшнээр үнэлэхэд хялбар болно.

Энэ даалгаврыг гүйцэтгэсэн сурагчдын хариултад шинжилгээ хийж үзье.

Энэ даалгавраас хүүхдийн 4 өөр гүйцэтгэл илэрнэ. Тухайлбал,

- Эхний хоёр даалгаварт ухнын бодсон бодлыг, хийсэн үйлдлийг сурагч ялгаж байвал тус тус нэг нэг оноо өгнө. Энэ нь шалгуурын 1 дүгээр түвшинд чадвар нь илэрч байгаа хүүхэд юм гэж үзнэ.
- Гурав дахь даалгаварт ухнын бодсон бодол, хийсэн үйлдлээс сурагч жишээ татан, хүний хувьд ямар зан чанартай болохыг тайлбарлаж байвал мөн оноо өгнө. Энэ нь шалгуурын 4 дүгээр түвшинд чадвар нь илэрч байгаа хүүхэд юм гэж үзнэ.

- Харин хүүхдийн хариултад ухнын бодсон бодлоос нь жишээ татаагүй зөвхөн хийсэн үйлдлээс нь жишээ татсан бол шалгуурын 3 дугаар түвшинд чадвар нь илэрч байгаа хүүхэд юм гэж үзнэ. Уг нь даалгаврын тавил нь “Бодсон бодол, хийсэн үйлдлээс нь ямар хүний зан чанарыг харуулсан бэ? Оновчтой жишээ татан тайлбарлан бичээрэй.” шүү дээ. Тэгэхээр эхний хоёр даалгаварт ухнын бодсон бодол, хийсэн үйлдлийг ялган бичдэг буюу эхний түвшиндээ хангалттай хариулж чадсан хүүхэд энэ хэсэгт илүү сайн оноо авах боломжтой юм.
- Харин хүүхэд ухнын бодсон бодол, хэлсэн үгээс жишээ татахгүй, өөр жишээ татан хүний дээрэнгүй, омог ихтэй зан чанарыг ухнаар хүншүүлсэн гэж бичиж байвал 2 дугаар түвшинд гүйцэтгэж байгааг харуулна.

ЕБС-ийн Монгол хэл хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

Ш.Оюунцэцэг	БМДИ-ийн зөвлөх багш
П.Одсүрэн	БМДИ-ийн арга зүйч, доктор (Ph.D)

Хөндлөнгийн шинжээч:

Ө.Цэндсүрэн	Монгол улсын гавьяат багш
-------------	---------------------------

Техникийн редактор:

Т.Отгон-Эрдэнэ	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, тэргүүлэх зэрэгтэй
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 3.5 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-мэйл: info@eec.mn Вэб: www.eec.mn